



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.05.29 № 289
танай _____-ны № _____-Т

**НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БАТТУЯА ТАНАА**

Нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэсэн “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн аудитын тайланг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б. Батмөнх* Б.БАТМӨНХ



4326070566
Албан бичиг А5 2026



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/109

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар болон аймгийн Засаг дарга (Н.Лхагвадорж), сумдын Засаг дарга нарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Т.Болор)-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор (Ц.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ ТОДОРХОЙ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИИЦЭЛ

АУДИТЫН КОД: СЭА-2026/14-17/ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх

Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Болор

Утас: 70362442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Сүхбаатар сум

2026 он

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгт, дүрслэл, хавсралтын жагсаалт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх?

1.1. Төрийн сангийн үйл ажиллагааны эрх зүйн актууд холбогдох хууль тогтоомжтой нийцэж байна уу?

1.2. Төрийн сангийн хууль тогтоомжийн хүрээнд хүлээсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх зохистой бүтэц бүрдсэн байна уу?

Бүлэг 2. Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх?

2.1. Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олголт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байна уу?

2.2. Төрийн сангийн нэгдсэн данс, төлбөр тооцооны үйл ажиллагаа хууль, журмын дагуу баталгаажин, нэгдсэн хяналттайгаар хэрэгжиж байна уу?

2.3. Төрийн сангийн үйл ажиллагаа, хяналтын тогтолцоо үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТТ	Албан тушаалын тодорхойлолт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИНХ	Иргэдийн Нийтийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТСУЦС	Төрийн сангийн удирдлагын цахим систем
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭБС	Эрхийн бүртгэлийн систем

Хүснэгтийн жагсаалт:

- Хүснэгт 1. Аймаг, сумдын төрийн сангийн албан хаагчдын бүтэц, орон тоо
- Хүснэгт 2. Аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын задаргаа
- Хүснэгт 3. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл
- Хүснэгт 4. Орлогын дансны буцаалт /сумдаар/
- Хүснэгт 5. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг мэдээлсэн байдал /сумдаар/

Дүрслэлийн жагсаалт:

- Дүрслэл 1. Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаарх санал асуулгын дүн
- Дүрслэл 2. Аймаг, сумдын төрийн сангийн гүйлгээ

Хавсралтын жагсаалт:

- Хавсралт 1. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг өөр хөтөлбөр, зориулалтын ангилалд нээж, зарцуулсан зөрчлийн жагсаалт
- Хавсралт 2. Аймаг, сумдын төрийн сангийн гүйлгээний дэлгэрэнгүй хүснэгт
- Хавсралт 3. Анхан шатны баримтын бүрдэл дутуу зарлагын гүйлгээ

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ СТАНДАРТЫН МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны “Аудитын сэдэв батлах тухай” 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын “Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө”-г үндэслэн хийв.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төрийн сангийн тогтолцоо оновчтой бүрдсэн эсэх;
- Төрийн сангийн үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар Монгол Улсад төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлсон бодлого, хууль тогтоомжийн нийцэл, аймгийн ЗДТГ-ын СТСХ болон сумдын төрийн сан, Төрийн сангийн удирдлагын цахим системийг /цаашид ТСУЦС гэх/ ашигладаг бусад төрийн байгууллагуудын 2023-2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бүтцийн зохион байгуулалт, чиг үүрэг оновчтой эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн, үр нөлөөнд үнэлгээ хийхээр холбогдох байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Дараах хууль, эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

Хууль:

- Төсвийн тухай;
- Төсвийн тогтвортой байдлын тухай;
- Засгийн газрын тусгай сангийн тухай;
- Шилэн дансны тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай;

Засгийн газрын тогтоол:

- Төрийн сангийн үйл ажиллагааны журам /2023 оны 444 дүгээр тогтоол/;
- Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам /2021 оны 51 дүгээр тогтоол/;
- Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам /2016 оны 29 дүгээр тогтоол/;

Сангийн сайдын тушаал:

- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт /2012 оны 294 дүгээр тушаал/;
- Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар /2016 оны 431 дүгээр тушаал/;
- “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал”, “төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар”, “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал /2025 оны 112 дугаар тушаал/;
- “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар” /2024 оны 254 дүгээр тушаал/;
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх заавар /2024 оны 256 дугаар тушаал/;
- Төрийн сангийн цахим системийн заавар /2024 оны 255 дугаар тушаал/;
- Төрийн үйлчилгээний төлбөрийг картаар хүлээн авах журам /Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/131 тоот тушаал/;

Монгол банкны Ерөнхийлөгчийн тушаал:

- Автомат клирин хаус системийн дүрэм /2021 оны А-128 тоот тушаал/;
- Их дүнтэй төлбөрийн системийн дүрэм /2025 оны А-229 тоот тушаал/;
- Монгол банкны төлбөрийн картын клирингийн системийн дүрэм /2022 оны А-135 тоот тушаал/;
- Төлбөрийн системийн журам /2023 оны А-91 тоот тушаал/.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Батмөнх удирдаж, ахлах аудитор Ц.Отгонбаяр явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, О.Анхбаяр, Ч.Сугардорж нар 2025 оны 04 дүгээр сарын 01-нээс 05 дугаар сарын 29-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.40-д *“төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнахыг”* гэж тодорхойлж, мөн хуулийн 35, 36, 37, 38 дугаар зүйлд төрийн сангийн нэгдсэн данс, тогтолцоо, нийтлэг чиг үүрэг, Төв төрийн сангийн чиг үүргүүдийг хуульчилсан байна.

Аймгийн хэмжээнд Санхүү, төрийн сангийн хэлтэс, 17 сум, 5 тосгоны төрийн сангийн нийт 23 нэгж, 49 орон тоотойгоор бүртгэлийн 897, орлогын 535, нийт 1432 дансаар төсөвт байгууллагуудад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлж байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга, ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч, төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн, төсвийн зарлагын мэргэжилтэн, төсвийн орлогын мэргэжилтэн, бүртгэлийн мэргэжилтэн тус бүр 1, төсөвт байгууллагын төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн 2, нийт 8 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа бол сум, тосгоны төрийн сангийн нэгжид 17 санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч, 2 төрийн сангийн төлөөлөгч, 22 төсөв, төрийн сангийн мэргэжилтэн ажиллаж байна.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ УЯЛДААГҮЙГЭЭС ТОГТОЛЦОО БҮРЭН УТГААРАА БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

ЗАРИМ АЛБАН ХААГЧИЙГ ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЗОХИЦУУЛАЛТ ТОДОРХОЙ БУС, ХЭРЭГЖИЛТ ХАРИЛЦАН АДИЛГҮЙ БАЙНА.

1.1.1 Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5¹, 36 дугаар зүйлийн 36.1², 36.2³ дахь заалтаар сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч болон төрийн сангийн нэгжийн харьяалал, томилгооны асуудлыг зохицуулсан.

1.1.2 Дээр дурдсан эрх зүйн зохицуулалтаар төрийн сангийн нэгж, санхүүгийн албыг тухайн шатны ЗДТГ-ын бүтцэд багтаасан тул төрийн сангийн нэгжийн бүтэц, орон тоог тухайн шатны ЗДТГ-ын даргын тушаалаар баталсан байна.

1.1.3 Сумдаасаа алслагдсан Бугант, Дулаанхан тосгоны төрийн сангийн төлөөлөгч, төсөв, төрийн сангийн мэргэжилтний бүтэц, орон тоог тосгоны Захирагчийн захирамжаар баталж, албан хаагчдыг томилж, чөлөөлсөн шийдвэрийг гаргасан байна.

1.1.4 Аудитад хамрагдсан 2023-2025 онд аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар СТСХ-ийн бүтцийг дарга 1, ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч 1, төрийн сангийн мэргэжилтэн 6 гэсэн нийт 8 орон тоотойгоор баталж, албан хаагчдыг томилж, чөлөөлсөн шийдвэрийг гаргаж, албан тушаалын тодорхойлолтыг баталж ажилласан байна.

1.1.5 Харин аймгийн ЗДТГ-ын төрийн үйлчилгээний албан хаагчдын бүтэц, орон тооны жагсаалтад 2023-2024 онд Нийтлэг үйлчилгээний албанд “Хөрөнгө оруулалт хариуцсан нягтлан бодогч”-ийн орон тоог баталж байсан бол 2025 онд “Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан хаагчдын бүтэц”-ийн 2 дугаарт “Санхүү, төрийн сангийн хэлтэс-Хөрөнгө оруулалт хариуцсан нягтлан бодогч” /ТҮМ-6/ гэж баталсан байна.

1.1.6 Засгийн газрын 2014 оны “Санхүүгийн алба байгуулах тухай” 326 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-т сумдад үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн үйлчилгээ хүргэх, сумын төсөв, санхүү, эдийн засаг, хөгжлийн бодлогын төлөвлөлт хариуцсан Санхүүгийн албыг байгуулж, албаны зохион байгуулалт, чиг үүрэг, орон тооны нормативыг баталсан.

1.1.7 Санхүүгийн албаны дарга нэршлийг Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт”-ийн **дэс түшмэл** ангиллын **ТЗ-7** зэрэглэлийн **“11.Сум, дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогч”** гэж заасантай нийцүүлэн 2024

¹ Сум, ... төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн төсвийн ерөнхий нягтлан бодогчийг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчтай, ... зөвшилцөн томилж, чөлөөлнө.

² Төрийн сангийн тогтолцоо нь ... аймаг нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, ... төсвийн нягтлан бодогчоос бүрдэнэ.

³ ... аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын тамгын газрын дэргэд байна.

онд бүх сумд албан тушаалын нэршлийг өөрчилсөн бөгөөд гаргасан тушаал, шийдвэрийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Орхон, Сайхан, Хушаат сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчийг сумын Засаг даргын захирамжаар,
- Бусад 14 сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчийг сумын ЗДТГ-ын даргын тушаалаар баталгаажуулсан байна.

1.1.8 Эндээс харахад сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчийг тухайн шатны Засаг дарга болон ЗДТГ-ын даргын шийдвэрээр томилж, чөлөөлсөн нь хуулийн зохицуулалт тодорхой бус байгааг илэрхийлж байна.

1.1.9 Иймд төсвийн ерөнхий нягтлан бодогч болон төрийн сангийн нэгжийн бүтэц, орон тоо, томилох, чөлөөлөх зохицуулалтыг холбогдох хууль, дүрэм, журамд уялдуулан нэг мөр тодорхой болгож, орон нутагт жигд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

СУЛ ОРОН ТООНД ХҮН ТОМИЛОГДОХГҮЙ БАЙГААГААС ӨӨРИЙН ХЯНАЛТ ТАВИХ АЛБАН ТУШААЛЫГ ОРЛОН ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА.

1.2.1 Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлд төрийн сангийн тогтолцоонд аймаг, сум гэсэн засаг захиргааны нэгжүүдэд төрийн сан байхаар, Засгийн газрын 2014 оны 326 дугаар “Санхүүгийн алба байгуулах тухай” тогтоолд тосгоны төрийн сан, санхүүгийн албаны талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүйгээс тосгодод санхүүгийн албаны зохион байгуулалт хийгдээгүй, төрийн сангийн үйл ажиллагааг нэгдсэн тогтолцоогоор зохион байгуулах нөхцөл бүрдээгүй байна.

1.2.2 Үүний улмаас тосгодод төрийн сангийн бүтэц, орон тоо, чиг үүргийг ялгаатай байдлаар хэрэгжүүлж, зарим тохиолдолд хуульд заагаагүй бүтэц, орон тоогоор төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1. Аймаг, сумдын төрийн сангийн албан хаагчдын бүтэц, орон тоо

№	Харьяалах төрийн сан	2023 он			2024 он			2025 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аймаг	8	8	-	8	8	-	8	7	1
2	Сум	41	36	5	41	38	3	41	37	4
	Нийт	49	44	5	49	46	3	49	44	5

Эх сурвалж: Төрийн сангийн судалгаа

1.2.3 Дээрх хүснэгтээс харахад 2023-2025 онуудад нийт батлагдсан 147 орон тооноос 13 орон тоо дутуу ажиллаж, аймаг, сумдын түвшинд албан тушаал хавсран болон түр орлон гүйцэтгэх нөхцөл байдал тогтмол үүссэн байна.

1.2.4 Үүний улмаас дараах албан тушаалтнуудад өөр албан тушаалын үүргийг түр орлон гүйцэтгүүлж, тухайн албан тушаалын цалингийн 40 хувийн нэмэгдлийг олгосон байна. Үүнд:

- ✓ 2023 онд Зүүнбүрэн сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь Санхүүгийн албаны даргын албан үүргийг, Баруунбүрэн, Орхон, Сайхан, Сүхбаатар сумын Санхүүгийн албаны дарга нар Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан үүргийг,
- ✓ 2024 онд Сүхбаатар сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь Санхүүгийн албаны даргын албан үүргийг, Зүүнбүрэн, Орхон сумын Санхүүгийн албаны дарга нар Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан үүргийг,

✓ 2025 онд Аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч нь аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргын албан үүргийг, Сүхбаатар сумын Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь Санхүүгийн албаны даргын албан үүргийг, Орхон, Сайхан, Мандал сумын Санхүүгийн албаны дарга нар Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан үүргийг тус тус түр орлон гүйцэтгэсэн.

1.2.5 Төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлыг санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч хавсран гүйцэтгэж байгаа нь тухайн АТТ-ын 2 дугаар зорилтын 7 дахь “Сумын төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний системд бүртгэсэн гүйлгээг төлбөрийн хүсэлт хяналтын хуудсыг үндэслэн баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2.6 Хэдийгээр орон нутагт мэргэжлийн боловсон хүчин хомс, сул орон тоонд хүн томилогдохгүй байгаа нөхцөл байдал нөлөөлсөн боловч энэ нь төрийн сангийн хяналтын тогтолцоо алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

1.2.7 Бугант, Дулаанхан тосгонд төрийн сангийн төлөөлөгч, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн тус бүр 2, Түнхэл, Хэрх, Номгон тосгонд төсөв, төрийн сангийн мэргэжилтэн тус бүр 1 гэсэн бүтцээр төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн заалттай зөрчилдөж байна. /Рашаант тосгонд төрийн сангийн нэгжгүй/

1.2.8 Бугант тосгоны төрийн сангийн төлөөлөгч, Дулаанхан тосгоны төсөв, төрийн сангийн мэргэжилтэн /Захирагчийн албанд батлагдаагүй бүтэц, орон тоонд төрийн сангийн гүйлгээ хянах эрхийг хэрэгжүүлдэг/ нь Захирагчийн албаны нягтлан бодогчийн ажлыг хариуцан гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцоонд тавих төрийн сангийн хяналтыг алдагдуулах эрсдэлтэй байна.

1.2.9 Бугант тосгоны Захирагчийн албаны төсөв, төрийн сангийн мэргэжилтний батлагдсан орон тоонд ажиллаж байгаа албан хаагч төрийн албан хаагчийн шалгалтад тэнцээгүй шалтгаанаар 2018 оноос одоог хүртэл ТҮ-8 зэрэглэлээр цалинжиж, төрийн сангийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

1.2.10 Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2⁴ дахь хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулж, 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр хуульчилсан нь тосгоны төрийн сангийн үйл ажиллагаа явуулах хууль, эрх зүйн үндсийг тодорхой болгосон байна.

1.2.11 Гэвч аймаг, сумдын төрийн санг тухайн шатны ЗДТГ-ын бүтэц, орон тоонд багтааж зохион байгуулсан, төрийн сангийн ажилтнуудыг аймаг, сумдын ЗДТГ-ын даргын тушаалаар томилж, чөлөөлөн, гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулсан нь тогтолцоо бүрэн утгаараа хэрэгжихгүй, төсвийн хэрэгжилтийг хангах, төлбөр тооцооны гүйлгээ хийх, тайлагнах, өдөр тутмын хяналтын үр нөлөө сулрах эрсдэлийг бий болгож байна.

⁴ ... аймаг, ... сум, ... төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд, ... тосгоны төрийн сан нь тухайн шатны Захирагчийн ажлын албаны дэргэд байна.

1.2.12 Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5⁵, 23 дугаар зүйлийн 23.6⁶-д заасны дагуу ТАЗ-өөс баталсан аймаг, сумдын төрийн сангийн албан хаагчдын АТТ-ыг баталгаажуулсан шийдвэрийг тодруулбал дараах байдалтай байна. Тухайлбал:

- ✓ Аймгийн СТСХ-ийн дарга: *ТАЗ-ийн 2025 оны 215 дугаар тогтоолоор баталсан АТТ-ыг аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны А/45 дугаар тушаалаар шинэчлэн баталгаажуулж,*
- ✓ Аймгийн СТСХ-ийн мэргэжилтнүүд: *ТАЗ-ийн 2022 оны 419 дүгээр тогтоолоор баталсан АТТ-ыг аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны А/71 дүгээр тушаалаар баталгаажуулж,*
- ✓ Сумдын санхүүгийн албаны дарга: *ТАЗ-ийн 2025 оны 208 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогч” АТТ-ыг тухайн сумын Засаг даргын захирамж болон ЗДТГ-ын даргын тушаалаар шинэчлэн баталгаажуулж,*
- ✓ Сумдын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн: *ТАЗ-ийн 2025 оны 208 дугаар тогтоолоор баталсан АТТ-ыг тухайн сумын ЗДТГ-ын даргын тушаалаар шинэчлэн баталгаажуулж, тус тус мөрдөж ажиллаж байна.*

1.2.13 ТАЗ-өөс 2019 онд батлагдсан төрийн сангийн албан хаагчдын АТТ-д заасан чиг үүргийг 2025 онтой харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга: *2019 онд батлагдсан АТТ-ын 3 дугаар зорилтын хүрээнд гүйцэтгэх “Төсвийн зарлагыг хэмнэх, зарцуулалтад гүйцэтгэлийн мониторинг хийх, дотоод аудитыг хэрэгжүүлэх” чиг үүргийг 2025 онд батлагдсан АТТ-д 1 дүгээр зорилтын хүрээнд “Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор дотоод аудит, хяналт шалгалт зохион байгуулах”, 3 дугаар зорилтын хүрээнд “Төсвийн үр дүнгүй зардлыг бууруулах, мониторинг хийх” гэж 2 хуваасан,*
- ✓ Сумын санхүүгийн албаны дарга: *2019 онд баталсан АТТ-д 39 чиг үүрэг байсан бол 2025 онд батлагдсан АТТ-д 7-оор нэмэгдүүлж, 46 чиг үүргийг баталсан,*
- ✓ Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн: *2019 оны АТТ-д 21 чиг үүргийг баталсан бол 2025 онд 8-аар нэмэгдүүлж, 29 чиг үүргийг баталсан байна.*

1.2.14 Харин аймгийн СТСХ-ийн мэргэжилтнүүдийн тухайд 2022 онд баталсан АТТ-оос өөр байхгүй тул нэмэгдсэн, хасагдсан талаар тодорхойлох боломжгүй байна.

1.2.15 Төрийн сангийн нийтлэг 8 чиг үүргийг Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлд тодорхойлсон, Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил, үүргийн жишиг заавар”-ыг баталсан бол дээрх зааврыг баримтлан 2023-2025 онд аймгийн СТСХ-ийн даргын тушаалаар хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн ажил үүргийн хуваарийг нарийвчлан тогтоож, баталгаажуулсан байна.

⁵ албан тушаалын тодорхойлолт гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг.

⁶ Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.

1.2.16 Хэдийгээр АТТ-д батлагдсан боловч СТСХ-ийн даргын 8, зарлагын мэргэжилтний 1, бүртгэлийн мэргэжилтний 3 чиг үүргийг ажил үүргийн хуваарьт тусгаагүй, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой нийт 26 ажил үүргийг албан хаагчдад нэмж тусгасан байна.

1.2.17 Мөн хөрөнгө оруулалт хариуцсан нягтлан бодогчийн талаар *“ТЕЗ-ийн ерөнхий нягтлан бодогч нь нийтлэг үйлчилгээний албаны хөрөнгө оруулалт хариуцсан нягтлан бодогчийн үйл ажиллагаанд хяналт тавих, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн баримтыг хянах”* гэж зааснаас өөрөөр тус албан хаагчийн хийх ажил үүргийг тусгаагүй нь ажил үүргийн давхардал, хариуцлагын тодорхой бус байдлыг үүсгэсэн байна.

1.2.18 Сумдад төрийн сангийн албан хаагчдын ажил үүргийн хуваарийг тусад нь баталж мөрдөөгүй учраас тодорхойлох боломжгүй байлаа.

1.2.19 Төрийн сангийн албан хаагчдаас авсан санал асуулгын дүн дараах байдалтай байна. Үүнд:

- *“Таны ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй нийцдэг уу?” гэсэн асуултад 77.6 хувь нь бүрэн нийцдэг, 22.4 хувь нь нийцдэггүй,*
- *“Ажлын байрны тодорхойлолтод тусгаагдаагүй өөр чиг үүргийг хэрэгжүүлдэг үү?” гэсэн асуултад 91.8 хувь нь үгүй, 8.2 хувь нь тийм гэж хариулсан байна.*

1.2.20 Хэдийгээр сумын Санхүүгийн албаны даргын АТТ-д тусгагдсан боловч дараах чиг үүргүүд хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нь зөрчилдөж, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бий болгож байна. Үүнд:

- *Сумын хэмжээнд төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах;*
- *Сум хөгжүүлэх сан /хуучин нэршлээр/, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн баримтад 2 дугаар гарын үсэг зурж тайлан баланс гаргах;*

1.2.21 Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, бүртгэх тайлагнах, санхүүжүүлэх, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг аймагт ЗДТГ-ын СТСХ, сумдад санхүүгийн алба хамтатган хэрэгжүүлж байгаа нь төсвийн захирагчийн холбогдох хууль тогтоомж зөрчин төлөвлөж, хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээг санхүүжүүлэх, төсвийн зарлагын дарааллыг журмын дагуу тогтоох, хяналт тавих үндсэн чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөл хангагдахгүй байх эрсдэлтэй байна.

1.2.22 Иймд төрийн сангийн албан хаагчдын АТТ, ажил үүргийн хуваарийг төрийн сангийн нийтлэг чиг үүрэгтэй уялдуулан дахин оновчтой боловсруулах, хяналт болон гүйцэтгэлийн чиг үүргийг салгах, ажлын ачааллыг бодит нөхцөлтэй нийцүүлэн зохицуулах, чиг үүргийн давхардлыг арилгах шаардлагатай байна.

1.2.23 Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5-д *“төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих”* гэж заасны дагуу төрийн сангийн үйл ажиллагааг finance.gov.mn цахим системээр дамжуулан гүйцэтгэж байна.

1.2.24 Сангийн сайдын 2024 оны 255 дугаар тушаалаар “Төрийн сангийн цахим системийн заавар”-ыг баталж, төрийн сангийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр шуурхай, ил тод, үр ашигтай хэрэгжүүлэх, хэрэглэгчийн эрхийн тохиргоо хийх, цахим системийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

1.2.25 Цахим системийн аюулгүй ажиллагааг хэрхэн хангаж ажиллах талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- *Нэгдсэн нэвтрэлтийн системд баталгаажуулсан бүртгэлтэй хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үгээр нэвтрэх, бусад хэрэглэгчийн эрхээр нэвтэрч ажил үүргийг гүйцэтгэхийг хориглоно,*
- *Нэвтрэх нэр, нууц үг, нэг удаагийн нууц үгийн нууцлалыг хадгалах, бусдад задруулахгүй байх, нууц үгээ алдсан тохиолдолд өмнө бүртгүүлсэн төхөөрөмжийг устгах, харьяа төрийн санд мэдэгдэх, эрхээ түр хаалгах, нууцлалыг задруулснаас үүсэх эрсдэлийг хэрэглэгч өөрөө хариуцна,*
- *Хэрэв гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй бол холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.*

1.2.26 Тус цахим системд аймгийн ЗДТГ-ын СТСХ болон 17 сум, 5 тосгоны 23 төрийн сангийн нэгжийн одоогийн байдлаар нийт 43 хэрэглэгч өөр, өөрийн хариуцсан байгууллага ажил, үүргийн хуваарийн дагуу нэвтэрч байгаа бөгөөд системд бүх төрийн сангийн нэгжүүд бүрэн хамрагдсан байна.

1.2.27 2023-2025 онд 2 сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, 6 сумын санхүүгийн албаны дарга давхар албан үүргийг гүйцэтгэж байсан бол 2026 онд Орхон сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нь санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчийг, Баруунбүрэн, Мандал, Сайхан, Сант сумын санхүүгийн албаны дарга буюу төсвийн ерөнхий нягтлан бодогчид сум, тосгоны төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан үүргийг тус тус түр орлон гүйцэтгэсэн хэвээр байна.

1.2.28 Төрийн сангийн цахим системд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчийн судалгааг авч үзэхэд дээр дурдсан шалтгаанаар 1 хэрэглэгчид гүйлгээ хянах, батлах, Төлбөр тооцоо хариуцсан ахлах мэргэжилтэн-ЭБС , Төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн-ЭБС эрхүүдийг давхардуулан олгосон байна.


1.2.29 Энэ нь Сангийн сайдын 2024 оны 255 дугаар тушаалаар баталсан “Төрийн сангийн цахим системийн заавар”-ын 2.7-д “Төрийн сангийн хэрэглэгчид гүйлгээ хянах болон батлах эрхийг давхардуулан олгохгүй” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2.30 Цахим системээр төрийн сангийн гүйлгээг хийх болсонтой холбогдуулан “Эрх шилжүүлэх хүсэлт” 2023-2025 онд гараагүй буюу гаргасан хүсэлт, баталгаажуулалт хийсэн талаар холбогдох нотлох баримтгүй байна.

1.2.31 Сангийн яаманд жил бүр аймаг, сумдын төрийн сангийн тамга, тэмдгийн нэгдсэн бүртгэл, ЗГУМС-д нэвтрэн ажилласан төрийн сангийн хэрэглэгчийн бүртгэлийг хавсралтаар гарган хүргүүлсэн байна.

1.2.32 Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаар аймгийн СТСХ, сумдын төрийн сангийн хэрэглэгч буюу хянах, батлах эрхтэй албан хаагчдаас авсан санал асуулгын дүнг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1. Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаарх санал асуулгын дүн



1.2.33 Төрийн сангийн цахим системийн ашиглалтын талаар төсвийн байгууллагын хэрэглэгчдээс авсан санал асуулгын дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Төрийн сангийн цахим систем таны ажлын хэрэгцээг хэр хангаж байна вэ? гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 76.0 хувь нь хэвийн, 24 хувь нь бүрэн хангаж байна,
- Төрийн сангийн цахим систем ашиглахад ямар хүндрэл бэрхшээл гардаг вэ? гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 43.8 хувь нь интернэтийн саатал, 17.9 хувь нь программ тасалдал, 13.1 хувь нь сургалт хангалтгүй гэх мэт,
- Төрийн сангийн цахим систем ашиглахад ойлгомжтой, хялбар байна уу? гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 82.8 хувь нь тийм, 17.2 хувь нь үгүй,
- Төрийн сангийн цахим системийн аюулгүй байдал хангагдсан гэж үзэж байна уу? гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 51.3 хувь нь мэдэхгүй, 42.1 хувь нь тийм, 6.6 хувь нь үгүй,
- Системүүд хоорондоо мэдээллээ үнэн зөв, шууд солилцож, уялдаа холбоотой ажиллаж чадаж байна уу? гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 77.7 хувь нь тийм, 22.3 хувь нь үгүй,
- Системд үүссэн асуудлыг систем хариуцагч байгууллагын зүгээс бүрэн, шуурхай шийдвэрлэдэг үү? гэсэн асуултад нийт хэрэглэгчийн 58.4 хувь нь тийм, 32.0 хувь нь удаашралтай, 9.6 хувь нь үгүй гэсэн хариултыг өгсөн байна.

1.2.34 Дээрх санал асуулгаас дүгнэж үзэхэд төсвийн байгууллагын хэрэглэгчдийн 51.3 хувь нь цахим системийн аюулгүй байдлын талаар “мэдэхгүй” гэж хариулсан нь мэдээллийн аюулгүй байдлын талаарх ойлголт, сургалт хангалтгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 2. ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨ СУЛ БАЙГААГААС ШАЛТГААЛАН ТӨРИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ БҮРЭН ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

НЭМЭЛТ ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ЭРХИЙГ ХӨТӨЛБӨР, ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ОЛГООГҮЙ БАЙНА.

2.1.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2-т “аймаг, нийслэлийн ИТХ тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах”, 8.5.4-т “сум, дүүргийн ИТХ тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор батлах” гэж заасан байна.

2.1.2 Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны Төсвийн тухай хуульд хориг тавьсны улмаас улсын төсөв хугацаа хоцорч батлагдсан, үүнтэй холбоотойгоор аймгийн 2025 оны төсвийг 2024 оны 12 дугаар сарын 25-нд баталж, төсвийн хуваарийг

Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/651 дүгээр захирамжаар баталсан байна.

2.1.3 Харин сумдын төсөв хуулийн хугацаанаас тус бүр 7-10 хоногоор хэтэрч батлагдсан, төсвийн сар, улирлын хуваарийг батлах хугацааг Төсвийн тухай хуульд тусгайлан зааж өгөөгүйгээс харилцан адилгүй баталж байна.

2.1.4 Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1.6⁷, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 2 зүйлийн 2.1.1⁸, 2.1.2⁹-т заасны дагуу аймаг, сумдад төсвийн зохицуулалтыг хийсэн байна.

2.1.5 Орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрхийг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.4¹⁰-т заасан дарааллыг баримтлан олгосон байна.

2.1.6 Аудитаар 2025 оны баримт материалыг түүвэрлэн тулган баталгаажуулахад Байгаль орчны газар, Санхүү хяналт дотоод аудитын алба, Орон нутгийн өмчийн газар зэрэг нийт 11 байгууллагын 1-2 дугаар сарын санхүүжилтийн эрхийг хуучин журмын маягтаар олгосон байна.

2.1.7 2023-2025 онд төсөвт байгууллагуудын зардлын санхүүжилтийг олгохдоо тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор бус ажлын 6-21 өдрийн дотор олгосон нь “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 зүйлийн 2.6-д “Орон нутгийн төсвийн санхүүжилтийн эрх олгох журам: 2.6.1: Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

2.1.8 Аймаг, сумдын төрийн сан нь Төсвийн тухайн хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8¹¹, “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2.6.1¹²-т гэж заасны дагуу төсвийн зарцуулалтын эрхийг сар, улирлын хуваарьт үндэслэн олгосон байна.

⁷ 42.2: “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: 42.2.1: төсвийн ерөнхийлөн захирагч нь: 42.2.1.б: түүнд шууд харьяалагдах төвлөрүүлэн захирагчдын төсөв хооронд”;

⁸ Төсвийн тогтвортой байдлыг хангах, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх үүднээс төсөвт зохицуулалт хийх шаардлага гарсан”;

⁹ Төсвийн захирагч болон түүний харьяа төсвийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад хууль, тогтоомжийн дагуу өөрчлөлт орсон, шинээр үүссэн, өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан

¹⁰ “Улсын болон орон нутгийн төсвийн санхүүжилт олгоход дараах зориулалт бүхий зардлын дарааллыг баримтална: 2.4.1 “Үндсэн үйл ажиллагааны зардал”, 2.4.4 “байр ашиглалтын зардал”, 2.4.8 “халамжийн санхүүжилт”, 2.4.9 “орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг”, 2.4.10 “Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгө”, 2.4.11 “ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг”, 2.4.12 “татаас санхүүжилт”, 2.4.13 “орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг”

¹¹ төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох

¹² Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь энэ журмын 2.4.1-2.4.9-д заасан зориулалт бүхий зардлын санхүүжилтийг тухайн сарын ажлын эхний 5 өдрийн дотор мөн журмын 23 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан олгоно

2.1.9 Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох талаар Төсвийн тухай хуулийн 37.1.8¹³, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 2.1¹⁴-д тус тус заасан байдаг.

2.1.10 Аудитаар 2025 оны баримт материалыг түүвэрлэн тулган баталгаажуулахад аймгийн төсвийн хуваарийн дагуу төв төрийн сангаас зарцуулалтын эрх олгосныг үндэслэн орон нутгийн 6 байгууллагад 12,997.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Аймгийн ИТХ 1,796.9 сая төгрөг;
- АЗДТГ 6,457.9 сая төгрөг;
- Байгаль орчны газар 3,489.7 сая төгрөг;
- Санхүү хяналт дотоод аудитын алба 439.2 сая төгрөг;
- Орон нутгийн өмчийн газар 455.4 сая төгрөг,
- Худалдан авах ажиллагааны газар 358.3 сая төгрөг;

2.1.11 Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана” гэж заасан байна.

2.1.12 Аудитаар 2025 оны баримтыг түүвэрлэн тулган баталгаажуулахад аймгийн Засаг даргын 2024 оны А/651 дүгээр захирамжаар 2025 оны сар, улирлын хуваарийг зардлын эдийн засгийн ангиллаар бус бөөн дүнгээр ИТХ-ын “Ангилалдаагүй бусад зориулалт” арга хэмжээг “210902:Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал”-ын ангилалд 255.0 сая төгрөгөөр, Байгаль орчны газрын “Байгаль хамгаалах нөхөн сэргээх” арга хэмжээг “210901: Бараа ажил, үйлчилгээний бусад зардал” ангилалд 941.8 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

2.1.13 Тухайлбал Байгаль орчны газрын Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2. Аймгийн Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын задаргаа

/сая төгрөг/

№	Зардлын эдийн засгийн ангилал	Гүйцэтгэл
1	Дотоод албан томилолтын зардал	36.9
2	Хөрөнгө оруулалт: Барилга байгууламж	392.9
3	Хөрөнгө оруулалт: Тоног төхөөрөмж, худалдан авах	308.5
4	Бусад хөрөнгө оруулалт	130.0
	Нийт дүн	868.3

Эх сурвалж: Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын гүйцэтгэл

2.1.14 2023-2025 онд аймаг, сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 11,072.5 сая төгрөгийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс хүлээн авсан. Үүнд:

¹³ Төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох.

¹⁴ Төрийн сан төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг Төсвийн тухай хуулийн 37.1.8-д заасны дагуу төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн олгоно.

- Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 502.5 сая төгрөг,
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 1,057.1 сая төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 9,512.9 сая төгрөг.

2.1.15 Ерөө сум 221.7 сая төгрөг, Мандал сум 96.5 сая төгрөг, Түшиг сум 60.5 сая төгрөг зэрэг аймгийн бүх сумд нийт 659.4 сая төгрөгийг өөр хөтөлбөр, зориулалтын ангилалд зарцуулалтын эрхийг нээж, зарцуулсан байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 1-д харуулав/*

2.1.16 Энэ нь Сангийн сайдын 2023 оны 444 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12.1-д “Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг өөрийн нэмэлт төсвийн дансаар дамжуулан хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулна” гэж заасныг зөрчсөн байна.

2.1.17 Эндээс үзэхэд төрийн сангийн зарлагын мэргэжилтэн нь сумдын ирүүлсэн нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлтийг хянаж, олгоогүйгээс алдаа, зөрчил гарсан байна.

ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ БҮРЭН БАТАЛГААЖААГҮЙ БАЙНА.

2.2.1 Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.10¹⁵-т заасны дагуу аймаг, сумдын төрийн сангийн нэгж нь төрийн сангийн дансны удирдлагыг хэрэгжүүлж, төлбөр тооцоог хийж, гүйцэтгэсэн байна.

2.2.2 Аймаг, сумдын төрийн сангийн нэгжээр 244 байгууллага нийт 1,432 бүртгэлийн данс ашиглан төрийн сангийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн байна. */Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав/*

2.2.3 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.24¹⁶-т төрийн сан нь төсөвт байгууллагуудын бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг хавсралтад заасан маягтын дагуу үйлдэж, хагас жил тутамд тооцоо нийлж, баталгаажуулахаар заасан байдаг.

2.2.4 Бүртгэлийн дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн байдлыг тулган баталгаажуулахад Баруунбүрэн, Сайхан, Сүхбаатар, Орхон сумдаас бусад 13 сумын төрийн сан нь бүртгэлийн 1132 дансны үлдэгдлийн баталгааг зөвхөн 1 хувь үйлдэж төсөвт байгууллагуудад хүргүүлсэн байна.

¹⁵ Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана.

¹⁶ Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан тушаалтан бүртгэлийн дансны үлдэгдлийн баталгааг мөн журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу үйлдэн хагас жил тутам харьяа төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулна.

2.2.5 Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн байгууллага, төрийн сангийн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он
1	Кассад байгаа бэлэн мөнгө	18.2	6.7	1.6
2	Төрийн сангийн харилцах	19,893.7	35,526.0	45,803.5
Дүн		19,911.9	35,532.7	45,805.1

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн 2023-2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.2.6 Дээрх хүснэгтээс харахад төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 2023 онд 19,911.9 сая төгрөг байсан бол 2025 онд 45,805.1 сая төгрөгт хүрч 2.3 дахин өссөн байна.

2.2.7 Үүнийг дагаад хяналт сайжрах шаардлагатай ч төрийн сангийн нэгжүүд нь харьяа байгууллагуудын бүртгэлийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж, нотлох баримтыг эх хувиар архивлахгүй байгаа нь журмын хэрэгжилт хангалтгүй, дотоод хяналт сул байгааг илтгэж байна.

2.2.8 Цагааннуур, Сайхан, Хүдэр, Хушаат, Мандал, Сант, Орхонтуул сумдаас бусад 5 сумын төрийн сангийн нэгжүүд нь 2023-2025 онд нийт 121 удаагийн орон нутгийн орлогын гүйцэтгэлийг татварын байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.7.3¹⁷-т заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

- *Баянгол сум нь 36, Сүхбаатар сум нь 35, бусад сумд нь 12-24 зэрэг нийт 50 орлогын гүйцэтгэлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.*

2.2.9 Энэ нь төсвийн орлогын мэдээ бодитой бус гарах, орлогыг залруулахгүй орхигдуулах, төсвийн орлого тасрах зэрэг эрсдэлийг үүсгэж байна.


2.2.10 Аймаг, сумдын төрийн сан нь 2023-2025 онд нийт 279,564 ширхэг, 1,293,914.9 сая төгрөгийн гүйлгээг */Дэлгэрэнгүйг Хавсралт 2-т харуулав/* хянаж, гүйцэтгэсэн байна. Үүнд:

- *2023 онд: 82,981 ширхэг гүйлгээгээр 322,785.7 сая төгрөг,*
- *2024 онд: 101,817 ширхэг гүйлгээгээр 453,245.7 сая төгрөг,*
- *2025 онд: 94,766 ширхэг гүйлгээгээр 517,883.5 сая төгрөг.*

2.2.11 Төрийн сангаар хийгдэж буй гүйлгээний тоог төрийн сангийн нэгжээр задалж харвал дараах байдалтай байна. Үүнд:

¹⁷ Орон нутгийн төсвийн орлогыг орлогын нэр төрөл болон орлого төвлөрүүлэгч байгууллагаар тооцоо нийлж баталгаажуулан санхүүжилт олгох ерөнхий орлогын дансанд ангилан бүртгэнэ.

Дүрслэл 2. Аймаг, сумдын төрийн сангийн гүйлгээ



Эх сурвалж: Аймаг, сумдын төрийн сангийн гүйлгээ

2.1.12 Дээрх дүрслэлээс харахад нийт гүйлгээний 28.0 хувийг аймгийн төрийн сан дангаараа гүйцэтгэсэн бол Мандал, Сайхан, Сүхбаатар сум нь 30.5 хувь, бусад 14 сумын төрийн сан нь нийт 41.5 хувийг гүйцэтгэсэн байна.

2.2.13 Аймаг болон Мандал, Сайхан, Сүхбаатар зэрэг сумдын төрийн сангийн нэгжийн албан хаагчид өндөр ачаалалтай ажилласнаар гүйлгээ бүрийн анхан шатны баримтын бүрдэлд тавих хяналт сулрах, алдаа гаргах, санхүүгийн сахилга бат, дотоод хяналт сулрах эрсдэлтэй байна.

2.2.14 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.9¹⁸, 3.5.8¹⁹-д заасан төлбөрийн хүсэлтийн хүчинтэй хугацаа болон гүйлгээ хаах цагийн хязгаарлалтыг “Төрийн сангийн удирдлагын цахим систем” автоматаар хянаж шийдвэрлэдэг болсон тул алдаа, зөрчил үүсэх эрсдэлгүй болсон байна.

2.2.15 Аудитаар 8 сумын 105 төсөвт байгууллагыг түүвэрлэн зарлагын гүйлгээний төлбөрийн хүсэлт дэх хяналтын хуудсанд бичигдсэн анхан шатны баримтын бүрдлийг тулган баталгаажуулахад 1,184.3 сая төгрөгийн дүнтэй 870 гүйлгээний нэхэмжлэх, гэрээ, зарлагын баримт, бүртгэлийн дансны хуулгыг бүрэн хавсаргаж үдээгүй байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт 3-т харуулав/

2.2.16 Аудитад хамрагдсан 23 төрийн сангийн нэгж, түүний харьяа 244 байгууллагууд нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.5²⁰, 3.5.6.2²¹ дахь заалтыг хэрэгжүүлэн ажилласан эсэхэд тулган баталгаажуулахад нэг, хоёрдугаар гарын үсэг зурах албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн тухай албан бичгээр мэдэгдээгүйгээс дараагийн албан хаагч томилогдох хүртэлх хугацаанд төрийн сангийн гүйлгээг түр зогсоох шаардлага үүсээгүй байна.

2.2.17 Төрийн сан, төсөвт байгууллагууд нь бүртгэлийн дансны төлбөр тооцоог Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.10²²-т заасан хөтөлбөр, зориулалт,

¹⁸ Төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлт нь бичигдсэн өдрийг оролцуулан ажлын 3 өдрийн хугацаанд хүчинтэй байна.

¹⁹ Төрийн сан нь сар бүрийн эцсийн ажлын өдөр 14 цагт зарлагын гүйлгээг хаана.

²⁰ Энэ журмын 3.4.1, 3.4.2-т заасан албан хаагч, байгууллагын нэр, бүртгэлийн дансны нэр, тамга, тэмдэг өөрчлөгдсөн тохиолдолд тухайн шийдвэр гарсан өдөр харьяа төрийн санд энэ тухай албан бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдээгүйгээс гарах үр дагаврыг мэдэгдэх үүрэгтэй этгээд хариуцна.

²¹ Төсвийн байгууллага энэ журмын 3.4.5-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурах албан тушаалтныг ажлаас чөлөөлөгдсөн өдрөөс дараагийн албан тушаалтан томилогдож, гарын үсгийн баталгааг ирүүлэх хүртэл.

²² Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн

арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу гүйцэтгэсэн эсэхийг тулган баталгаажуулахад алдаа, зөрчил илрээгүй болно.

2.2.18 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4.22.2-т заасны дагуу аймаг, сумдын 535 орлогын дансаар 2023 онд 5,571.6 сая төгрөг, 2024 онд 7,108.4 сая төгрөг, 2025 онд 8,178.9 сая төгрөг зэрэг нийт 21,158.9 сая төгрөгийн 2,023 татварын орлогын залруулга, буцаалтын гүйлгээ хийгдсэн байна.

2.2.19 Дээрх орлогын залруулга, буцаалтын гүйлгээний 70.8 хувийг буюу 14,989.4 сая төгрөгийг ХХОАТ-ын буцаалт эзэлж байна.

2.2.20 Аудитаар орлогын залруулга, буцаалтын гүйлгээний анхан шатны баримтын бүрдлийг шалгахад нийт 617 удаагийн 799.8 сая төгрөгийн гүйлгээг хийхдээ орлогын дэлгэрэнгүй хуулгыг хавсаргаагүй байна.

2.2.21 Энэ нь Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4.21 дэх *“Төсвийн байгууллага орлогын хуулгыг өдөр тутам хянаж, тодорхой бус орлогын талаар нягталж, орлого бууруулах гүйлгээг гаргахдаа холбогдох нотлох баримт болон орлогын дэлгэрэнгүй хуулгыг төлбөрийн хүсэлтийн хамт хавсаргаж ...”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хүснэгт 4. Орлогын дансны буцаалт /сумдаар/

/сая төгрөг/

№	Төрийн сангийн нэгжийн нэр	Орлогын данс	2023 он		2024 он		2025 он		Журам зөрчсөн гүйлгээ	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг	25	233	2,049.1	261	2,529.4	378	5,078.6	-	-
2	Алтанбулаг	30	12	65.9	7	73.7	5	18.5	-	-
3	Ерөө	30	6	108.2	5	93.2	2	213.0	-	-
4	Зүүнбүрэн	29	8	24.8	16	152.3	2	57.9	11	15.7
5	Мандал	33	158	1,590.4	163	1,113.5	176	994.7	119	596.1
6	Орхон	31	2	18.1	2	41.0	1	39.6	-	-
7	Сант	29	3	74.6	4	31.8	3	20.2	-	-
8	Цагааннуур	29	6	34.7	10	46.1	12	62.1	-	-
9	Баянгол	31	5	94.4	2	94.9	2	138.3	-	-
10	Сайхан	32	67	270.3	97	460.7	106	386.6	99	16.4
11	Орхонтуул	29	2	40.5	1	50.5	2	48.7	-	-
12	Баруунбүрэн	29	5	41.7	24	128.6	2	22.3	-	-
13	Шаамар	31	21	67.6	20	69.9	23	76.5	32	10.7
14	Хүдэр	29	22	525.3	30	1,441.7	10	57.0	22	33.2
15	Сүхбаатар	31	32	813.4	26	689.1	28	888.3	-	-
16	Жавхлант	29	1	22.1	1	28.7	-	-	-	-
17	Түшиг	29	2	12.4	6	35.3	3	38.9	-	-
18	Хушаат	29	3	17.8	2	27.9	3	37.7	-	-
	НИЙТ	535	588	5,871.6	677	7,108.4	758	8,178.9	283	672.1

Эх үүсвэр: Орон нутгийн орлогын дансны зарлагын дэлгэрэнгүй тайлан

2.2.22 Дээрх хүснэгтээс харахад нийт зөрчлийн 97.5 хувийг дараах сумдын зөрчил эзэлж байна. Үүнд:

- Мандал сум 119 гүйлгээгээр 596.1 сая төгрөг,
- Сайхан сум 99 гүйлгээгээр 16.4 сая төгрөг,
- Хүдэр сум 22 гүйлгээгээр 33.2 сая төгрөг,

засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана

- Зүүнбүрэн сум 32 гүйлгээгээр 10.7 сая төгрөг.

2.2.23 Мандал сум нь орлогын хуулгыг хянаж, нягтлаагүй, холбогдох нотлох баримтгүйгээр 2023 онд Түмэндалай ХХК-д 0.5 сая төгрөг, Д.Отгонтуяа, Т.Уянга нарт тус бүр 0.6 сая төгрөгийн буцаалтыг хийж гүйцэтгэсэн байна.

2.2.24 Орон нутгийн орлогын залруулга, буцаалтын гүйлгээнд тавих хяналт хангалтгүй байгаа нь цаашид хүчин төгөлдөр бус баримтаар буцаан олголт хийх, гүйлгээг давхардуулах улмаар татварын орлого тасрахад хүргэж болзошгүй байна.

2.2.25 Төсөвт байгууллагууд нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1²³-д заасны дагуу хагас жил, жилийн эцсийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж харьяалагдах дээд шатны байгууллагад хүргүүлсэн боловч 1 болон 3 дугаар улирлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, хүргүүлээгүй байна.

2.2.26 Хагас, бүтэн жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 4.1.6.3²⁴-т заасны дагуу тооцооны тайлангийн хамт дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

2.2.27 Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр ... тайлагнана”, 8 дугаар зүйлийн 8.8.1-д “төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх” гэж заасан байна.

2.2.28 17 сумын 46 төсөвт байгууллага тайлант хугацаанд нийт 1656 төсвийн гүйцэтгэлийн мэдээг төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээс 556 буюу 30.4 хувийг хугацаа хоцроосон, 53 буюу 3.2 хувийг огт ирүүлээгүй зөрчил гаргасан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг мэдээлсэн байдал /сумдаар/

№	Сумын нэр	Байгууллагын тоо	Нийт мэдээлэх тоо	Нийт зөрчилтэй мэдээний тоо	Үүнээс:	
					Мэдээ ирүүлээгүй	Хуулийн хугацаанд ирүүлээгүй
1	Алтанбулаг	2	72	41	10	31
2	Ерөө	3	108	34	9	25
3	Зүүнбүрэн	2	72	37	1	36
4	Мандал	5	180	39	7	32
5	Орхон	2	72	38	26	12
6	Сант	2	72	43	-	43
7	Цагааннуур	3	108	3	-	3
8	Баянгол	2	72	60	-	60
9	Сайхан	4	144	18	-	18
10	Орхонтуул	3	108	87	-	87
11	Баруунбүрэн	3	108	44	-	44
12	Шаамар	4	144	65	-	65

²³ Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх.

²⁴ Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсөв хоорондын тооцооны тайланг төсвийн шууд захирагч тус бүрээр тулган баталгаажуулж, албажуулан төсвийн ерөнхийлөн захирагчид эхний хагас жилийн тайланг 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

13	Хүдэр	2	72	0	-	-
14	Сүхбаатар	3	108	0	-	-
15	Жавхлант	2	72	2	-	2
16	Түшиг	2	72	40	-	40
17	Хушаат	2	72	5	-	5
НИЙТ		46	1656	556	53	503

2.2.29 Дээрх хүснэгтээс харахад дараах нийтлэг зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- Орхон сумын 2 төсөвт байгууллага нь 26 гүйцэтгэлийн мэдээг огт гаргаж ирүүлээгүй,
- Орхонтуул сум 87, Шаамар сум 65, Баянгол сум 60 зэрэг нийт 207 гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроож ирүүлсэн нь 42.1 хувийг эзэлж байна.

2.2.30 Сумдын харьяа төсөвт байгууллагуудын төсвийн шууд захирагч, нягтлан бодогчид нь төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаандаа, бүрэн тайлагнаагүй, төсвийн сахилга батыг мөрдөж ажиллаагүй зэргээр хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

ДОТООД ХЯНАЛТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТИЙГ ГАРГАЖ ХҮРГҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮР ДҮНГ ТООЦОХ ТАЛААР ЖУРАМД ТУСГАЙЛАН ЗААГААГҮЙ БАЙНА.

2.3.1 Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг хэрэгжүүлэх талаар Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6²⁵, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9²⁶, 3.9.1²⁷, Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-т тус тус тусгасан байна.

2.3.2 Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврын дагуу эрсдэлд суурилсан зарчмыг баримтлан аймаг нь төлөвлөгөөг Засаг даргаар, удирдамжийг СТСХ-ийн даргаар, сумд нь төлөвлөгөөг харьяалах ЗДТГ-ын даргаар батлуулан, дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

2.3.3 Дотоод хяналтыг санхүүжилт болон тайлагналын хяналт, төлбөр тооцоо, системийн хяналт, төрийн сангийн дотоод үйл ажиллагааны хяналт, эрхийн бүртгэлийн сан систем, портал систем гэсэн 6 үндсэн чиглэлээр гүйцэтгэсэн байна. /2024 онд баталсан удирдамжаас харахад/

2.3.4 Аймгийн төрийн сангаас Сангийн яаманд 2023-2025 онд хүргүүлсэн тайлангаас харахад төрийн сангийн 23 нэгжээс 17 нэгжид дотоод хяналт хэрэгжүүлсэн дүн мэдээтэй боловч 11 нэгжид тайлан хүргүүлж, илэрсэн алдаа, зөрчилтэй холбогдуулан давхардсан тоогоор 60 зөвлөмж өгсөн байна.

²⁵ Төв төрийн сан нь аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан болон төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын төрийн сан нь сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.

²⁶ Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт:

²⁷ Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 36.6-д заасны дагуу хэрэгжүүлэхдээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын зааврыг мөрдлөг болгоно;

2.3.5 Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 6 дугаар зүйлийн 6.2-т “Дотоод хяналтыг дараах чиглэлээр зохион байгуулж ажиллана : 6.2.14: Дотоод хяналтын нэгтгэсэн тайлан, зөвлөмжийн биелэлтийг хугацаандаа хүргүүлсэн эсэхийг хянах;” гэж заасан.

2.3.6 Сүхбаатар сумын төрийн санд 2024 онд хийсэн дотоод хяналтаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийн тайланг сумын ЗДТГ-ын даргын 2025 оны 03/231 дугаар албан бичгээр гаргаж хүргүүлсэн, бусад сумдаас зөвлөмжийн биелэлтийг хүлээн авч, үр дүнг тооцоогүй нь дотоод хяналтын үр нөлөөг бууруулж байна.

2.3.7 Аудитад хамрагдсан 2023-2025 онд төлөвлөгөөт бус хяналт хийгдээгүй байна.

2.3.8 Сумдын төрийн сангийн тухайд дотоод хяналтаар илэрсэн алдаа, зөвлөмжийг албажуулан хүргүүлээгүй, хэрэгжилтийн тайлан аваагүй, үр дүнг тооцож хэвшээгүй байна.

2.3.9 Харин Цагааннуур сум дотоод хяналтын шинэчилсэн зааврын дагуу 2025 онд давхардсан тоогоор 15 байгууллагад хяналтыг хэрэгжүүлж, илэрсэн 117 алдаа, 142 зөвлөмжийг сумын Засаг даргын “Үүрэг чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллага тус бүрд хүргүүлж, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайланг бүх байгууллагаас хүлээн авч, хэрэгжилтийг 100 хувь дүгнэсэн нь дотоод хяналтын зөв зохион байгуулалтын сайн жишээ болсон байна.

2.3.10 Энэ нь дотоод хяналтын зөвлөмжийг албажуулж, хэрэгжилтэд хяналт тавих нь үр дүнтэй болохыг харуулж байна.

2.3.11 Аймгийн СТСХ-ийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн 2025 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Сант сумын төлбөр тооцоонд системийн түвшинд түүвэрлэж, **өдөр тутмын** хяналтыг хэрэгжүүлж, ЕБС 5, ЭМТ 4, ЗДТГ 11, Цэцэрлэг 1, нийт 21 алдаа илрүүлж, цаашид анхаарах 6 асуудлыг танилцуулсан байна.

2.3.12 Сангийн сайдын 2024 оны 254 дүгээр тушаалаар баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын заавар”-ын 5.1.1²⁸-д заасны дагуу сумдын төрийн сан нь эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайланг аймгийн төрийн санд ирүүлсэн байдлыг 2025 оны байдлаар авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- *Өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, хавсралт 3-т заасан эрсдэлийн түвшнийг нэгдсэн хүснэгтэд бөглөн бүх сумд ирүүлсэн,*
- *Хавсралт 10-т заасан эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайланг бүх сумд ирүүлээгүй, харин Хавсралт 8-д заасан дотоод хяналтын тайланг Орхон, Сайхан, Сүхбаатар сум, Номгон, Дулаанхан, Түнхэл, Хэрх тосгоноос бусад бүх сумд ирүүлсэн байна.*

²⁸ Сум, дүүргийн төрийн сан нь энэ зааврын хавсралт 1, 2, 4-6-д заасны дагуу өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, энэ зааврын хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн түвшнийг нэгдсэн хүснэгтэд бөглөн, энэ зааврын хавсралт 10-т заасны дагуу эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлангийн хамт дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн төрийн санд хүргүүлнэ.

2.3.13 Дээр дурдсан зааврын 5.1.3²⁹, 8.1³⁰-т заасны дагуу аймгийн төрийн сангаас дотоод хяналттай холбоотой материалыг төв төрийн санд хүргүүлсэн байдлыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- 2023 оны тайланг аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 02/33 дугаар,
- 2024 оны тайланг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/41 дугаар,
- 2025 онд заавар шинэчлэгдсэнтэй холбогдуулан Хавсралт 3-т заасны дагуу аймгийн болон сумдын төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэсэн “Эрсдэлийн үнэлгээний нэгдсэн хүснэгт”, Хавсралт 8-д заасны дагуу сумдын “Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн дотоод хяналтын тайлан”, Хавсралт 9-т заасан “Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан”, Хавсралт 10-т заасан “Төрийн сангийн үйл ажиллагаанд учирсан эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлан”-г аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/123 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн байна.

2.3.14 Төрийн сангийн дотоод хяналтын үр дүн, илэрсэн алдаа зөрчил, зөвлөмжийг бүрэн баримтжуулж тайланд тусгах, эрсдэлийн удирдлагын тайлан болон дотоод хяналтын тайланг бүрэн ирүүлэхэд хяналт тавих, хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

2.3.15 Сангийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөө, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/114 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн үйл ажиллагаанд 2023-2024 оны баримт материалыг хамруулан дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

2.3.16 Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журмын дагуу тус хэлтэст эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшин “**дунд**” буюу хяналтыг “маш сайн” хэрэгжүүлэн ажилласан гэж дүгнэн, төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль, тогтоомж, журам, зааврын дагуу мөрдөж ажиллах 13 зөвлөмжийг өгсөн байна.

2.3.17 Сангийн яамны төрийн сангийн газраас хийсэн дотоод хяналтаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан ажлын тайланг аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 02/739 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.

2.3.18 Сангийн яамнаас хийсэн дотоод хяналтаар өгсөн “Төрийн болон албаны нууцад хамаарах төсөвт байгууллагын албан бичиг, гарын үсгийн баталгааны маягт, төлбөрийн хүсэлт болон бусад холбогдох нууц баримт бичгүүдийн хадгалалт хамгаалалтыг ... зөвхөн төрийн санд хамаарах нууцын гүйлгээ,

²⁹ Аймаг, нийслэлийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан нь энэ зааврын хавсралт 1,2, 4-6-д заасны дагуу өөрийн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг хийж, харьяа төрийн сангаас ирүүлсэн эрсдэлийн үнэлгээг нягталж, энэ зааврын хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн түвшнийг нэгдсэн хүснэгтэд нэгтгэж, энэ зааврын хавсралт 10-т заасны дагуу эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлангийн хамт дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор төв төрийн санд хүргүүлнэ.

³⁰ Аймаг, нийслэлийн төрийн сан нь дотоод хяналтын нэгтгэсэн тайлан, зөвлөмжийн хэрэгжилтийг тухайн шатны засаг даргад танилцуулж, энэ зааврын хавсралт 8-д заасан дотоод хяналтын тайлангийн загварын дагуу нэгтгэн, энэ зааврын хавсралт 9-д заасан зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, эрсдэлийн үнэлгээний нэгтгэлийн хамт төв төрийн санд дараа оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн дотор цахимаар болон албан бичгээр хүргүүлнэ.

баримт бичгийг хууль, журмын дагуу хадгалж, архивын нэгж үүсгэн **цоожтой сейфт хадгалж, нууцын архивын ажилтанд** хүлээлгэн өгөх;" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, баримтыг аймгийн ЗДТГ-ын архивд энгийн баримттай адил хадгалсан байна.

2.3.19 Төрийн сангийн үйл ажиллагааны журамд нууцын гүйлгээ хийх, баримт материалын хадгалалт, хамгаалалтын зохицуулалт тодорхой тусгагдаагүйгээс 2023 онд нууцын байгууллагын материалыг аймгийн хөрөнгө оруулалтын гүйлгээнүүдтэй хамт архивын нэгж үүсгэн, хадгалсан байна.

2.3.20 Сэлэнгэ аймаг дахь Тагнуулын газраас 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 43/65 дугаар албан бичгээр дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Х.Оюунбилэг, төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн У.Дөлгөөн нарт төрийн болон албаны нууцтай танилцах, албаны нууц баримт бичиг хадгалах эрх олгосон бол төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн Б.Ариунчимэгт эрх олгогдоогүй байхад 2023 онд төрийн сангийн гүйлгээг хийж, архивын нэгжийг бэлтгэн, хүлээлгэн өгсөн байна.

2.3.21 Иймд төрийн сангийн үйл ажиллагаанд нууцын баримт бичгийн хадгалалт, хамгаалалт, архивлах асуудлыг тодорхой болгох талаар тусгах шаардлагатай байна.

ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт 1,333.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт, 1,331.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Төлбөрийн акт:

- Мандал сум нь орлогын хуулгыг хянаж, нягтлаагүй, холбогдох нотлох баримтгүйгээр 2023 онд Түмэндалай ХХК-д 0.5 сая төгрөг, Д.Отгонтуяа, Т.Уянга нарт тус бүр 0.6 сая төгрөгийн Орон нутгийн орлогын буцаалтын гүйлгээг хийж гүйцэтгэсэн.

2. Албан шаардлага:

- Сумдын нэмэлт төсвийн дансаар хүлээн авсан **659.4** сая төгрөгийн санхүүжилтийг өөр хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилалд зарцуулалтын эрх нээлгэж, зарцуулсан.
- Орлогын залруулга, буцаалтын гүйлгээнд **5** сум **672.1** сая төгрөгийн орлогын дэлгэрэнгүй хуулгыг хавсаргаагүй.
- Орлогын гүйцэтгэлийг **5** сум татварын байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төрийн санг тухайн шатны ЗДТГ-ын бүтцэд багтааж зохион байгуулсан, тосгоны төрийн сангийн талаар хуульд тусгаагүй нь тогтолцоо бүрэн утгаараа бүрдээгүйг харуулж байна.
- Сумдын төсвийн сар, улирлын хуваарийг батлах хугацааг хуульд тусгайлан зааж өгөөгүйгээс харилцан адилгүй баталж байна.
- Орон нутгийн орлогын гүйцэтгэлийг татварын байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
- Орлогын залруулга, буцаалтын гүйлгээнд тавих хяналт хангалтгүй байгаагаас төсвийн орлогыг үндэслэлгүйгээр бууруулах эрсдэлтэй байна.
- Төсөвт байгууллагууд нь төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаандаа, бүрэн тайлагнахгүй байна.
- Сумдаас аймагт ирүүлэх эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн тайлан, зөвлөмжийн биелэлтийг ирүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

СТСХ-ийн дарга /Б.Энхтуяа/-д

- Эрсдэлийн удирдлагын мөрөөр хэрэгжүүлсэн болон дотоод хяналтын тайланг сумдаас бүрэн хүлээн авч, үр дүнг тооцож үнэлэх.

Аймаг, сумдын төрийн сан-д

- Дотоод хяналт хэрэгжүүлсэн тухай бүр тайланг хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь хүлээн авч, үр дүнг тооцож байх.
- Байгууллагын нэг, хоёрдугаар гарын үсэг зурах албан тушаалтан өөрчлөгдсөн тухай бүр мэдэгдлийг хүлээн авч, зарлагын гүйлгээг түр зогсоож байх.
- Төсөвт байгууллагуудын бүртгэлийн дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулж байх.
- Төсөвт байгууллагын анхан шатны баримтын бүрдэл, архивласан байдалд хяналт хэрэгжүүлж байх.
- Харьяа төсвийн байгууллагуудаас санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуульд заасан хугацаанд нь хүлээн авч, баталгаажуулж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



Ч. СУГАРДОРЖ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА


Аймгийн Засаг даргын Тамгын газрын I байр, Их суварга 505,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг, 43081
Утас: Факс: 7036-2223, Цахим шуудан: azdtg@selenge.gov.mn
Цахим хуудас: www.selenge.gov.mn

2021.05.28 № 01/625

танай _____-ны № _____

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Төрийн сангийн тогтолцоо, хууль тогтоомжийн нийцэл” сэдэвт нийцлийн аудитын дүгнэлтийг уншиж танилцлаа. Санал байхгүй болно.



Н.ЦАХГАВДАРЖ

4326090677

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг өөр хөтөлбөр, зориулалтын ангилалд нээж, зарцуулсан зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

1324100019 9055456

Зарлага

№	Сумд	Байгууллага	Орлого	Зарлага		Орлого	Зарлага					Орлого	Зарлага			Орлого	
				70106	70106		70106	70106	70106	70106	70106		70503				
		Хөтөлбөр	70106	70106	70106	70106	80101	80102	80103	81518	81518	80101	80102	80103	81102	83401	
		Зориулалт	81101	80102	81102	81102											
		Эх үүсвэр	350013		350013	350014					350014						
1	Алтанбулаг	ЗДТГ	29.2	29.2	1.1			0.1		1.0	1.1	1.0	0.1				
2	Баруунбүрэн	ЗДТГ			2.3		2.3				2.0	1.5	0.5				
3	Баянгол	ЗДТГ			3.4			3.4			1.1		1.1				
4	Ерөө	ЗДТГ	35.3		35.3	10.0	10.0				59.3				39.3	20.0	
5		Бугант ЗА				7.7		7.7				7.5	7.3			0.2	
6	Жавхлант	ЗДТГ			2.1	2.1					1.5				1.5		
7	Зүүнбүрэн	ЗДТГ	6.7		6.7						1.4	1.2			0.2		
8	Мандал	ЗДТГ	68.0	68.0		5.0		5.0			23.5	23.5					
9	Орхон	ЗДТГ			36.8		1.0	35.8			3.0	3.0					
10	Орхонтуул	ЗДТГ			1.8			1.8			4.9		4.5		0.4		
11	Сайхан	ЗДТГ			2.9	1.5	1.4				0.6	0.4	0.2				
12	Сант	ЗДТГ			8.2	8.0		0.2			2.8		1.8	1.0			
13	Сүхбаатар	ЗДТГ									2.3				2.3		
14	Түшиг	ЗДТГ	41.7		41.7	17.0	16.0	1.0			1.2	0.2			1.0		
15	Хушаат	ЗДТГ	20.7	20.7		7.0		6.0	1.0		1.4		0.1	1.3			
16	Хүдэр	ЗДТГ	35.9		35.9	5.2		3.2		2.0	12.0	11.0			1.0		
17	Цагааннуур	ЗДТГ	49.9		49.9	0.1		0.1			1.8	0.2			1.6		
18	Шаамар	ЗДТГ	5.3	5.3		1.5		0.5		1.0	1.1	0.9	0.1		0.1		
19		Дулаанхан ЗА				9.6		9.6			1.3	1.1	0.2				
Нийт дүн			292.7	123.2	169.5	121.7	27.6	41.7	47.4	4.0	1.0	129.8	51.3	8.6	2.3	47.6	20.0

Нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрхийг өөр хөтөлбөр, зориулалтын ангилалд нээж, зарцуулсан зөрчлийн жагсаалт

/сая төгрөг/

1324100015 9055436

Орлого Зарлага
дүн дүн

№	Сумд	Байгууллага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага		Орлого	Зарлага	Орлого	Зарлага	Орлого	Зарлага	
										Орлого	Зарлага							
		Хөтөлбөр	72207	70106	70405	70106	70405	70106	70708	70106	70106	71701	70106	71507	70106			
		Зориулалт	80237	80102	81517	81517	81526	80101	81517	80101	81517	82106	80101	80404	81518			
		Эх үүсвэр	350014		350014		350014		350014			350014		350014				
1	Алтанбулаг	ЗДТГ															31.4	31.4
2	Баруунбүрэн	ЗДТГ															4.3	4.3
3	Баянгол	ЗДТГ															4.5	4.5
4	Ерөө	ЗДТГ	0.6	0.6								0.8	0.8				106.0	106.0
5		Бугант ЗА												100.5	100.5			115.7
6	Жавхлант	ЗДТГ															3.6	3.6
7	Зүүнбүрэн	ЗДТГ															8.1	8.1
8	Мандал	ЗДТГ															96.5	96.5
9	Орхон	ЗДТГ					1.0	1.0									40.8	40.8
10	Орхонтуул	ЗДТГ															6.7	6.7
11	Сайхан	ЗДТГ															3.5	3.5
12	Сант	ЗДТГ															11.0	11.0
13	Сүхбаатар	ЗДТГ															2.3	2.3
14	Түшиг	ЗДТГ	0.6	0.6													60.5	60.5
15	Хушаат	ЗДТГ	0.6	0.6													29.7	29.7
16	Хүдэр	ЗДТГ			0.9	0.9			1.5		1.5						55.5	55.5
17	Цагааннуур	ЗДТГ							1.5	1.5							53.3	53.3
18	Шаамар	ЗДТГ															7.9	7.9
19		Дулаанхан ЗА	3.2	3.2								4.0	4.0				18.1	18.1
	Нийт дүн		5.0	5.0	0.9	0.9	1.0	1.0	3.0	1.5	1.5	4.8	4.8	100.5	100.5		659.4	659.4


Хавсралт 2

/сая төгрөг/

1324100015 9005436

Төрийн сангийн данс, байгууллага, зарлагын гүйлгээний жагсаалт

№	Төрийн сангийн нэгжийн нэр	Нийт дансны тоо	Байгууллагын тоо	Зарлагын гүйлгээ									
				2023 он		2024 он		2025 он		Нийт			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Нийт тоонд эзлэх хувь	Дүн	Нийт дүнд эзлэх хувь
1	Аймаг	209	44	23898	148,406.9	29149	208,546.6	25333	232,874.1	78380	28.0	589,827.6	45.6
2	Алтанбулаг	62	8	2351	5,805.2	3071	8,655.1	1373	4,497.8	6795	2.4	18,958.1	1.5
3	Ерөө	60	9	2556	11,170.7	3278	15,278.0	3168	15,899.9	9002	3.2	42,348.6	3.3
4	Зүүнбүрэн	53	7	1514	3,924.0	1923	6,118.2	1868	6,816.5	5305	1.9	16,858.7	1.3
5	Мандал	133	26	12250	45,792.6	16185	58,987.3	13532	63,328.8	41967	15.0	168,108.7	13.0
6	Орхон	56	7	1105	2,803.8	1499	3,988.1	1367	4,678.1	3971	1.4	11,470.0	0.9
7	Сант	57	7	1935	3,401.7	2316	4,960.3	2383	5,978.5	6634	2.4	14,340.5	1.1
8	Цагааннуур	61	10	2756	6,213.0	3279	10,047.9	3028	11,501.3	9063	3.2	27,762.2	2.1
9	Баянгол	64	8	1922	6,511.7	2352	9,746.7	2498	10,967.4	6772	2.4	27,225.8	2.1
10	Сайхан	87	15	4361	14,770.6	5382	21,436.0	5115	25,414.2	14858	5.3	61,620.8	4.8
11	Орхонтуул	68	11	2067	5,359.0	2748	8,114.8	2639	9,118.2	7454	2.7	22,592.0	1.7
12	Баруунбүрэн	58	9	2042	4,661.9	2119	6,285.0	2199	8,316.6	6360	2.3	19,263.5	1.5
13	Шаамар	59	8	1988	4,512.0	2220	5,880.2	2938	10,209.7	7146	2.6	20,601.9	1.6
14	Хүдэр	56	7	2253	8,369.5	2601	9,461.1	2856	12,309.8	7710	2.8	30,140.4	2.3
15	Сүхбаатар	99	20	8702	25,730.6	10180	36,356.4	9740	43,046.7	28622	10.2	105,133.7	8.1
16	Жавхлант	54	7	1554	3,591.6	2041	5,417.7	2090	6,286.5	5685	2.0	15,295.8	1.2
17	Түшиг	55	7	1853	3,782.1	2058	5,916.7	1837	7,130.2	5748	2.1	16,829.0	1.3
18	Хушаат	54	7	1326	3,177.7	1811	5,058.3	1576	5,732.0	4713	1.7	13,968.0	1.1
19	Бугант	17	5	1490	3,440.8	1705	5,115.0	1793	6,263.1	4988	1.8	14,818.9	1.1
20	Дулаанхан	19	6	1338	2,357.7	1519	3,902.8	1608	4,695.7	4465	1.6	10,956.2	0.8
21	Номгон	17	5	1143	2,303.6	1227	3,626.3	1264	4,355.9	3634	1.3	10,285.8	0.8
22	Түнхэл	17	6	1258	3,189.6	1631	4,868.7	2740	12,021.3	5629	2.0	20,079.6	1.6
23	Хэрх	17	5	1319	3,509.4	1523	5,478.3	1821	6,441.4	4663	1.7	15,429.1	1.2
НИЙТ ДҮН		1432	244	82981	322,785.7	101817	453,245.7	94766	517,883.5	279564	100.0	1,293,914.9	100.0



Төсөвт байгууллагын анхан шатны баримтын бүрдэл, архивласан байдалд илэрсэн зөрчлийн жагсаалт

№	Сумын нэр	Гүйлгээний дүн	Мөнгөн дүн
1	Алтанбулаг сум	164	220.4
2	Ерөө сум	246	109.0
3	Зүүнбүрэн сум	195	265.7
4	Мандал сум	68	347.2
5	Баянгол сум	2	1.5
6	Сайхан сум	195	240.5
НИЙТ		870	1,184.3

/сая төгрөг/